



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

1995 оны 10. дугаар
сарын 12. өдөр

Дугаар АР.11.

Улаанбаатар
хот

Дүрэм батлах тухай

1. Монгол улсын Засгийн газрын 178 тоот тогтоолыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Нийслэлийн Засаг даргын 1995 оны 30 тоот захирамжаар тохижилтын ажил Захирагчийн ажлын албаны харъяалалд очсон тул Барилга, хот тохижилтын газрын нэрийг өөрчилж Барилга, хөрөнгө оруулалтын газар болгосугай.

2. Захирагчийн ажлын албаны харъяа Барилга хөрөнгө оруулалтын газрын дүрмийг хавсралтаар баталсугай.


3. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 1993 оны 07 дугаар сарын 19-ны өдрийн А\141 тоот захирамжийн хавсралтаар баталсан Барилга, хот тохижилтын газрын дүрмийг хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БҮСЭЭД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Ц.Баасанжав

Ц.БААСАНЖАВ



ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ ХАРЬЯА
 БАРИЛГА, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН
 Ү Р Э М

Нэг.Нийтлэг үндэслэл.

1.Барилга хөрөнгө оруулалтын газар нь нийслэлийн хөрөнгө оруулалттай орон сууц, соёл, ахуй, нийтийн үйлчилгээний зориулалттай барилга байгууламж бариулах, өргөтгөх, шинэчлэх, засварлах, зам гүүр, далан суваг, инженерийн шугам сүлжээний ажилд хөрөнгө оруулалт, захиалагчийн хяналтын бодлогыг хэрэгжүүлэх Захирагчийн албаны харъяа байгууллага мөн.

2.Барилга, хөрөнгө оруулалтын газар нь үйл ажиллагаандаа Монгол улсын хууль тогтоомж, холбогдох дээд байгууллагын захирамж, шийдвэрийг удирдлага болгоно.

3.Барилга, хөрөнгө оруулалтын газар нь Нийслэлийн ерөнхий менежерийн удирдлагын дор ажиллаж, даргыг нь ерөнхий менежерийн тушаалаар томилно.

4.Барилга, хөрөнгө оруулалтын газрын дарга нь ажиллагсдыг томилох, ажлаас чөлөөлөх асуудлыг тушаалаар шийдвэрлэнэ.

5.Тус газар нь тогтоогдсон журмын дагуу хийгдсэн тэмдэг, албан бичиг, хэвлэмэл хуудсыг хэрэглэнэ.

6.Барилга, хөрөнгө оруулалтын газар нь нийслэлийн ерөнхий менежерийн өмнө ажлаа хариуцан тайлагнана.

Хоёр.Барилга, хөрөнгө оруулалтын газрын үүрэг.

1.Хөрөнгө оруулалт, хөрөнгө төвлөрүүлэлт, техник хяналтын бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх, үйл ажиллагааг зохион байгуулж хяналт тавих.

2.Шинээр баригдах болон өргөтгөл шинэчлэлт хийгдэх барилга, байгууламжийн техник, эдийн засгийн үндэслэл тооцоо-зургийн даалгаврыг боловсруулан зураг төслийг захиалан хийлгэх.

3.Барилга, хөрөнгө оруулалтын талаар гарч буй норм дүрэм, журмыг мөрдөх, сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавих.

4.Хотын захиалгаар баригдах барилга байгууламж, их засварын ажилд шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээг тооцон, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулах, төлөвлөгдсөн хөрөнгийг төвлөрүүлэх, санхүүжилтийн үйл ажиллагаанд хяналт тавих.

5.Нийслэлийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэж буй бүхий л барилга угсралт, их засвар тохижилтын ажлыг мэргэжлийн гүйцэтгэгч байгууллагуудын удирдлагад заавал тендер зарлан шалгуулж хийлгэн санхүүжүүлж байх.

6. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр баригдах барилга байгууламж, их засварын ажлыг гүйцэтгэгч байгууллагатай хэлцэл хийж, аж ахуйн гэрээ байгуулах.

7. Гүйцэтгэгч байгууллагатай байгуулсан гэрээний дагуу хөрөнгө төвлөрүүлж санхүүжилтийг хугацаанд нь хийх, барилгын технологи, чанар, гэрээний үүрэг хариуцлагыг анхаарч ажиллах.

8. Барилга угсралт, их засварын ажилд техникийн хяналтыг тогтоосон журмын дагуу явуулах.

9. Өөрийн харъяа байгууллагын удирдах ажилтнуудыг мэргэжлийн удирдлагаар хангаж, гэрээ байгуулан үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллах.

10. Дээд байгууллагын тогтоол шийдвэрийг цаг тухайд нь хэрэгжүүлэх.

11. Хөрөнгө оруулалтын санхүүжилт, барилга угсралт, их засварын ажил, ашиглалтанд оруулах хүч чадал, үндсэн фондын гүйцэтгэлийг сар бүр гаргаж холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргэх,

12. Барилга, хөрөнгө оруулалтын газар нь орлогоороо зарлагаа нөхөж ажиллах.

Гурав. Барилга, хөрөнгө оруулалтын газрын эрх.

Барилга, хөрөнгө оруулалтын газар нь доор дурьдсан эрхийг эдэлнэ. ҮҮНД:

1. Барилга байгууламж, инженерийн шугам сүлжээний угсралтын ажилд батлагдсан зургийг зөрчиж, чанаргүй хийгдсэн тохиолдолд ажлыг зогсоож буруутай этгээдийн зардлаар дахин гүйцэтгүүлэх.

Хэрэв буруутай этгээд уг зөрчлийг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд тухайн байгууллагын үйл ажиллагааг зөрчил арилгатал зогсоох.

2. Олгогдсон хөрөнгийг зориулалтын бус ашигласан этгээдийг холбогдох банк, санхүү, хуулийн байгууллагатай хамтран төлбөрийг зохих хууль, дүрмийн дагуу барагдуулах.

3. Стандарт, техник, технологийн горим зөрчсөн материал, хийц эдлэл үйлдвэрлэх, нийлүүлэх, ашиглахыг хориглох.

4. Мэргэжлийн байгууллагатай тохиролцон хяналт шалгалтын ажлыг хамтран явуулах, илэрсэн зөрчил доголдлыг зохих хууль дүрмийн дагуу хариуцлага хүлээлгэх.

5. Бүх төрлийн барилга байгууламж, их засвар, хот тохижилтын ажлыг хийж дууссаны дараа ажлын чанарын баталгааг гүйцэтгэгч байгууллага хариуцах хугацааг тогтоон, ажил бүр дээр баталгаат хугацааны үед хяналт тавьж, гарсан хохирол эвдрэл гэмтлийг арилгуулж байх.

6. Барилга, хөрөнгө оруулалтын газар нь өөрийн хариуцсан ажлын чиглэлээр асуудал боловсруулж зохих дээд байгууллагад тавьж шийдвэрлүүлэх.